УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

ПАРЛАМЕНТЫН
СУДАЛГАА
ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

ОЛОН ОРОЛЦОГЧТОЙ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: СТ-24/213

Захиалагч:	Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэл
Хянасан:	Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгийн захирал Д.Бумдарь (Ph.D)
Удирдсан:	ПСХХ-ийн хэлтсийн дарга Ц.Норовдондог (Ph.D)
Судлаачид:	Б.Батцэцэг, Э.Дашзэгвэ, Р.Нургул

Улаанбаатар хот
2024 он

АГУУЛГА

УДИРТГАЛ 3

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ХЭСЭГ 4

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ 6

НЭГ. МОНГОЛ УЛСЫН ОЛОН ОРОЛЦОГЧТОЙ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ 6-10

ХОЁР. ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ 10

ХОРВАТ 10

ЭСТОНИ 14

АШИГЛАСАН МАТЕРИАЛ 17

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн О.Алтангэрэлийн захиалгаар “Олон оролцогчтой эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх зарим улсын эрх зүйн зохицуулалт” сэдэвт харьцуулсан судалгааг Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго*:* Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмын талаарх Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдал, практик асуудлууд болон зарим улсын эрх зүйн зохицуулалт, туршлагыг судлах.

Судалгааны хамрах хүрээ*:* Энэхүү судалгаанд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг судлахын зэрэгцээ Эстони, Хорват зэрэг орнуудыг хамруулж, эдгээр орнуудын туршлагыг эрх зүйн зохицуулалтын хүрээнд харьцуулан судлав.

Судалгааны бүтэц*:* Судалгаа нь үндсэн хоёр хэсэгтэй.

Нэгдүгээр хэсэгт, Монгол Улсын олон оролцогчтой эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэж буй өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалтын талаар,

Хоёрдугаар хэсэгт, Судалгаанд авагдсан орнуудын олон оролцогчтой эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалтын талаарх мэдээллийг тус тус оруулав.

Түлхүүр үг*:* *шүүгдэгч, оролцогч, шүүх хурал, олон оролцогчтой шүүх хурал, олон шүүгдэгчтэй шүүх хурал, шүүх хуралдааныг үргэлжлүүлэх, шүүх хуралдааныг хойшлуулах*

Key words*:* *defendant, participant, trial, trial with several participant, trial with several defendant, continuing the trial/to proceed the trial/, to postpone the trial*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ ХЭСЭГ

Монгол Улсад олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх явцад шүүх хуралдаан олон дахин хойшилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нь оролцогчийн эрхийг зөрчих, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг сулруулах, шүүхийн зардлыг нэмэгдүүлэх зэрэг олон сөрөг талтай учир шүүх хэрэг маргааныг боломжит богино хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэх арга замыг эрэлхийлж, мэргэжлийн байгууллагуудын зүгээс янз бүрийн судалгаа, дүгнэлтүүдийг гаргасан байдаг.

Шүүх хуралдааныг шүүгч, шүүх бүрэлдэхүүн гагцхүү хуульд заасан үндэслэлийн дагуу хойшлуулдаг. Хэдийгээр шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой заасан боловч практикт шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах, улмаар шүүн таслах ажиллагаа удаашрах, хэргийн оролцогчдын эрхийг зөрчих, чирэгдүүлэх явдал гарсаар байна. Ялангуяа, олон оролцогчтой эрүүгийн хэргийн тухайд шүүхээс оролцогч нэг бүрийн үндсэн болон процессын эрхийг хангахын тулд шүүх хурлыг хойшлуулдаг талаар судалгаанд тусгагджээ. *(дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү)*

Эрүү, иргэн, захиргааны хэргийн төрлөөс үл хамааран шүүх хуралдааныг хамгийн их хойшлуулсан тохиолдол нь *өмгөөлөгчөөс* хамааралтай байх бөгөөд шалтгааныг нарийвчлан авч үзэхэд хамгийн их тохиолдлыг өмгөөлөгч нь шүүх хуралдаан давхацсан, өмгөөлөгч нь эрүүл мэндийн шалтгаантай, өмгөөлөгч нь хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан, өмгөөлөгч нь шүүх хуралдаанд шалтгаангүйгээр ирээгүй, өмгөөлөгчийн оролцсон өмнөх шүүх хуралдаан дуусаагүй гэсэн үндэслэлээр өмгөөлөгч өөрийн үйлчлүүлэгчид ашигтай байдлыг үүсгэх зорилгоор шүүх хуралдааныг удаа дараалан хойшлуулах хандлагатай байна.

Мөн практикт *шүүх хуралдаанууд* олноороо хойшлох, олон удаа хойшлуулах нь шүүх эрх мэдлийн нэр хүндийг унагах, шүүн таслах ажиллагаанд иргэдийг чирэгдүүлэх сөрөг хандлагатай юм. Ийнхүү шүүх хуралдаан олноор, удаа дараалан хойшилж буй нь дээр дурдсанчлан эрүү, иргэн, захиргааны хэргийн процессын хуулиудад заасан үндэслэлийн дагуу байхаас гадна шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын зохион байгуулалт сул байх, шүүх хуралдааны бэлтгэл хангалтгүй, шүүх хуралдааны танхим хүрэлцээгүй зэрэг үр дагавраас үүсэлтэй байна.

Нөгөө талаас, *хэргийн оролцогчийн* хүсэлтээр шүүх хуралдааныг ихээр хойшлуулж байгаа тохиолдлууд байна. Энэ нь хэргийн оролцогч өвчтэй, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилолттой, өвчтэй тул хойшлуулах шалтгаан болж байна.

Дээрх учир шалтгааны улмаас шүүх хуралдаан дараалан хойшилж байх тул цаашид шүүх хуралдаан хойшлуулж буй үндэслэлийг цогцоор нь шийдвэрлэхэд анхаарах нь зүйтэй байна.. гэж судлаачид үзжээ.

Сэдвийн хүрээнд авч үзвэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.18 дугаар зүйлд зааснаар хэргийг тусгаарлаж хэлэлцэх боломжтой боловч үндэслэл нь хязгаарлагдмал буюу зөвхөн шүүгдэгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон үед хэргийг тусгаарлаж эцэслэн шийдвэрлэхээр хуульчилсан байна. Хэрэв энэхүү зохицуулалтын үндэслэлийг нэмэгдүүлж, шүүх хуралдааныг хойшлуулах шалтгаан болоод байгаа өмгөөлөгч гэх мэт бусад оролцогч ирээгүй тохиолдолд тусгаарлаж хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлбэл шүүн таслах ажиллагаа удаашрах эрсдэлийг бууруулах боломжтой гэж үзэж байна.

СУДАЛГААНД АВАГДСАН ОРНУУДЫН ТУРШЛАГА

Хорват улс

Хорват Улсын эрх зүйн систем нь Ром Германы буюу эх газрын эрх зүйн бүлд багтдаг бөгөөд бичмэл хууль, дүрэм журамд суурилсан тогтолцоотой.

Тус улсын эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагаа, түүн дотор олон оролцогч буюу хэд хэдэн яллагдагчтай хэргийн хянан шийдвэрлэх журмыг Үндсэн хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албаны тухай хууль, Хүний эрхийн тухай Европын конвенц зэргээр тус тус зохицуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэлийг;

- Шүүх хуралдааныг үргэлжлүүлэх өдөр, цагийг тухайн шүүх хуралдааныг хойшлуулах шийдвэрт боломжтой бол тодорхой тусгах;
- Шүүх цаг хугацааны явцад үрэгдэж, алга болж болзошгүй нотлох баримтыг нэн даруй олж авахыг тухайн шийдвэрээр холбогдох эрх бүхий албан тушаалтанд даалгах;
- Улсын яллагч ирээгүй тохиолдолд шүүх хурлыг хойшлуулах;
- Гэрч, шинжээч шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол шүүх хуралдаанд гаргах мэдүүлэг, тайлбарын ач холбогдлыг харгалзан шүүх тус хуралдааныг хойшлуулах, эсхүл завсарлуулах;
- Хэд хэдэн яллагдагч хэд хэдэн гэмт хэрэгт үйлдсэн тохиолдолд тэдгээрийн үйлдсэн гэмт хэрэг нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд нотлох баримт нэг байх тохиолдолд тэдгээрийн хэргийг хамтатгаж нэгтгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болно.
- Мөрдөн шалгах ажиллагааны явцад хангалттай нотлох баримт цугларсан тохиолдолд хэрэгт холбогдсон бүх яллагдагч нарт хамтарсан яллах дүгнэлт үйлдэх;
- Яллах дүгнэлтэд яллагдагч нэг бүрийн гүйцэтгэсэн үүрэг, үйлдэл, гэм буруу түүнчлэн тухай гэмт хэрэгт хамтран оролцсон оролцооны шинж чанар байдлыг ялгаж салган тусгасан байх ёстой гэж зааж өгчээ.

Эстони улс

Эстони Улсад олон оролцогчтой эрүүгийн гэмт хэргийг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулж байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэлийг;

- Хуульд заасны дагуу гэрч, хохирогч эсхүл шинжээч, прокурор, өмгөөлөгч, яллагдагч шүүх хуралдаанд ирээгүй;
- Нэмэлт нотлох баримт шаардлагатай;
- Хэлэлцүүлгийн явцад өөр эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэх сэжүүр үүссэний улмаас эрүүгийн хэргийг хэлэлцэхэд хүндрэлтэй болсон;
- Шүүх хуралдааныг өөр бусад шалтгааны улмаас үргэлжлүүлэх боломжгүй болсон зэрэг орно гэж тус тус заасан байна.

Хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцох шаардлагатай этгээд ирээгүйн улмаас шүүх хуралдааныг хойшлуулсан бөгөөд ийнхүү ирээгүй нь хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаантай биш бол шүүхээс хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ болон албадан ирүүлэх, эсхүл оргон зайлсан гэж зарлах зэрэг арга хэмжээг авч болохоор тусгасан байна.

Өмгөөлөгч шүүх хуралдааны талаар мэдээлэлгүй байгаа бол шүүх хуралдааныг 10 хүртэл хоногоор хойшлуулж, тус хуралдаан хойшлуулсантай холбогдох хуралдааны үйл ажиллагааны зардлыг өмгөөлөгчөөс гаргуулж болно. Энэ тухай Өмгөөлөгчдийн холбооны удирдлагад мэдэгдэнэ.

Шүүх хуралдаан хойшлуулсан тохиолдолд түүнийг үргэлжлүүлэн явуулах хугацааг нэн даруй товлох, хуралдааныг аль болох богино хугацаанд хойшлуулах, хойшлуулсны дараа үргэлжлүүлэхдээ эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй явуулна гэсэн зарчмыг баримтлана гэж заасан байна.

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ХЭСЭГ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Монгол Улсын олон оролцогчтой эрүүгийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэж буй өнөөгийн нөхцөл байдал, эрх зүйн зохицуулалт

Нийтлэг үндэслэл

НҮБ-аас 1948 онд батлан гаргасан *Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 10 дугаар зүйлд* “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй.” хэмээн дэлхий дахинаа тунхаглан зарласан юм. Энэхүү эрхийн баталгааг хангах зорилгоор 1966 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоолоор батлан гаргасан, гишүүн улсын хувьд заавал биелэгдэх хууль зүйн шинжтэй Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 3-т “Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу байгуулагдсан шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ боломжийн богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй.” гэж, мөн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн (с)-д “Зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдсэн байх наад захын баталгаагаар хангагдах эрхтэй.” гэж тус тус заасан нь шүүхийн процесс боломжит богино хугацаанд хурдан шуурхай явагдах ёстойг харуулж байна.

Түүнчлэн, дээрх зүйл заалтын агуулгыг тайлбарласан НҮБ-ын Хүний эрхийн хорооны ерөнхий тайлбар /№32, §14, 2014/-т “14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн (с)-д заасан зүй бусын хойшлуулалтгүйгээр шүүгдсэн байх эрх нь хүний удаан хугацаанд хэрхэх нь тодорхой бус байлгахаас сэргийлэх төдийгүй, шүүх хуралдаан үргэлжлэх явцад хоригдож байгаа бол шударга ёсыг тогтооход зайлшгүй боловч хэргийн нөхцөлд шаардагдахаас илүү хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлахгүй байхад үйлчилнэ. Шүүх хэргийг боломжтой богино хугацаанд шүүх хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Энэхүү баталгаа нь зөвхөн анхан шатны шүүх ажиллагаа төдийгүй давж заалдах зэрэг шүүхийн бүх үе шатанд хамааралтай.” хэмээн хууль хэрэглээний албан ёсны тайлбар хийжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.” гэж, 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж тус тус заасан тул Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу шүүх хуралдааныг аль болох боломжит богино хугацаанд явуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх учиртай.

Алсын хараа 2050 Ухаалаг засаглал I үе шат (2021-2030)-ын 3-т Шүүхийн хараат бус байдал хангагдаж, хариуцлагатай, иргэн төвтэй шүүх тогтолцоо төлөвшинө, I үе шат (2031-2040)-ын 3-т Иргэдийн итгэлийг бүрэн хүлээсэн шүүхтэй болно, III үе шат 2041-2050)-ын 3-т Хариуцлагатай, иргэн төвтэй шүүх төлөвшсөн байхаар зорьсон байна.

Монгол Улсын шүүх эрх мэдлийн хөгжлийн бодлого 2024 онд батагдсан уг урт хугацааны хөгжлийн баримт бичигт Шүүхэд мэдүүлэх иргэний эрхийн баталгааг хангаж, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг дээшлүүлэх; Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хариуцлагатай шүүхийг төлөвшүүлэх; Шүүх эрх мэдлийн байгууллагын захиргааны менежментийг хөгжүүлэх; Шүүхийн хүний нөөцийн чадавхыг хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тасралтгүй хөгжүүлэх; Шүүхийн үйлчилгээний чанар,

хүртээмжийг нэмэгдүүлэх; Шүүхийн үйлчилгээний дэд бүтцийг хөгжүүлэх; Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тохирсон, тогтвортой, урьдчилан тооцоолсон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх зэрэг асуудлыг цогцоор нь тусгажээ.

Нөхцөл байдлын судалгаа

Шүүх хуралдаан олон дахин хойшилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах нь оролцогчийн эрхийг зөрчих, олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг сулруулах, шүүхийн зардлыг нэмэгдүүлэх зэрэг олон сөрөг талтай учир шүүх хэрэг маргааныг боломжит богино хугацаанд түргэн шуурхай шийдвэрлэх арга замыг эрэлхийлж дараах байгууллагууд нөхцөл байдлын судалгаа хийсэн байна. Үүнд;

Шүүхийн захиргааны сургалт, судалгааны төвөөс*:*

- “Эрүү, иргэн, захиргааны хэргийн хавтаст хэрэгт хийсэн баримт бичгийн судалгааны тайлан” 2022 он
- “Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь” 2023 он,
- “Шүүхийн өнөөгийн нөхцөл байдлын тандалт судалгаа” 2023 он

Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгээс:


- “Шүүх хуралдаан хойшлуулсан, шүүхээс хэрэг түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа” 2015 он

Шүүхийн практик судлалын хэлтсийн “Анхан шатны шүүхээс шүүх хуралдаан хойшилж буй байдал, түүний шалтгаан нөхцөлийн судалгаа” 2023 онд тус тус судалгааг хийжээ. Тус судалгаануудыг нэгтгэн харьцуулж үзвэл;

Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд заасан шалтгаан нөхцөлийг судлахад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхээс шалтгаалсан 44 тохиолдол буюу 6.8 хувь, прокуророос шалтгаалсан 109 тохиолдол буюу 16.9 хувь, шүүгдэгчээс шалтгаалсан 77 тохиолдол буюу 11.9 хувь, шүүгдэгч өмгөөлөгч авах хүсэлт гаргасан 78 тохиолдол буюу 12.0 хувь, өмгөөлөгчөөс шалтгаалсан 192 тохиолдол буюу 29.7 хувь, бусад шалтгаанаар 146 тохиолдол буюу 22.7 хувийг тус тус эзэлж байна.

Өөрөөр хэлбэл, шүүгдэгчээс өмгөөлөгч авах хүсэлт гаргасан, өмгөөлөгчөөс иргэний хариуцагч, нэхэмжлэгч, хохирогч, гэрч, шинжээч шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт гаргасан, өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй үндэслэлээр нийт хойшлуулсан тохиолдлын 46.1 хувийг эзэлж байна.[1]

[1] Шүүх хурал хойшлох шалтгаан нөхцөлийг тодруулах нь*:* *https://judcouncil.mn/file/research/3.pdf*



Эх сурвалж: https://judcouncil.mn/file/research/3.pdf

Шүүх хуралдааныг шүүгч, шүүх бүрэлдэхүүн гагцхүү хуульд заасан үндэслэлийн дагуу хойшлуулдаг. Хэдийгээр шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой заасан боловч практикт шүүх хуралдааныг удаа дараа хойшлуулах, улмаар шүүн таслах ажиллагаа удаашрах, хэргийн оролцогчдын эрхийг зөрчих, чирэгдүүлэх явдал гарсаар байна. Ялангуяа, олон оролцогчтой эрүүгийн хэргийн тухайд шүүхээс оролцогч нэг бүрийн үндсэн болон процессын эрхийг хангахын тулд шүүх хурлыг хойшлуулдаг талаар судалгаанд тусгагджээ.

Эрүү, иргэн, захиргааны хэргийн төрлөөс үл хамааран шүүх хуралдааныг хамгийн их хойшлуулсан тохиолдол нь *өмгөөлөгчөөс* хамааралтай байх бөгөөд шалтгааныг нарийвчлан авч үзэхэд хамгийн их тохиолдлыг өмгөөлөгч нь шүүх хуралдаан давхацсан, өмгөөлөгч нь эрүүл мэндийн шалтгаантай, өмгөөлөгч нь хэргийн материалтай танилцах хүсэлт гаргасан, өмгөөлөгч нь шүүх хуралдаанд шалтгаангүйгээр ирээгүй, өмгөөлөгчийн оролцсон өмнөх шүүх хуралдаан дуусаагүй гэсэн үндэслэл мөн өмгөөлөгч өөрийн үйлчлүүлэгчид ашигтай байдлыг үүсгэх зорилгоор өвчтэй, хурал давхардсан, өмгөөлөгчөөс татгалзах зэрэг олон асуудлаар шүүх хуралдааныг удаа дараалан хойшлуулах хандлагатай байна.

Шүүгч, шүүх бүрэлдэхүүн хэргийг хуульд заасан хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй. Харин хуульд заасан тодорхой үндэслэл, шалтгаан бий болсон тохиолдолд шүүх хуралдааныг хойшлуулах нь зүйн хэрэг. Гэвч практикт шүүх хуралдаанууд олноороо хойшлох, олон удаа хойшлуулах нь шүүх эрх мэдлийн нэр хүндийг унагах, шүүн таслах

ажиллагаанд иргэдийг чирэгдүүлэх сөрөг хандлагатай юм. Ийнхүү шүүх хуралдаан олноор, удаа дараалан хойшилж буй нь дээр дурдсанчлан эрүү, иргэн, захиргааны хэргийн процессын хуулиудад заасан үндэслэлийн дагуу байхаас гадна шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын зохион байгуулалт сул байх, шүүх хуралдааны бэлтгэл хангалтгүй, шүүх хуралдааны танхим хүрэлцээгүй зэрэг үр дагавраас үүсэлтэй байна.

Нөгөө талаас, *хэргийн оролцогчийн* хүсэлтээр шүүх хуралдааныг ихээр хойшлуулж байна. Энэ нь хэргийн оролцогч өвчтэй, итгэмжлэгдсэн төлөөлөгч томилолттой, өвчтэй тул хойшлуулах шалтгаан болж байна. Түүнчлэн өмгөөлөгчийн оролцоотойгоор шүүх хуралдааныг хойшлуулж буй асуудлыг орхилгүй өнгөрч болохгүй. Дээрх учир шалтгааны улмаас шүүх хуралдаан дараалан хойшилж байх тул цаашид шүүх хуралдаан хойшлуулж буй үндэслэлийг цогцоор нь шийдвэрлэхэд анхаарах нь зүйтэй байна.

Хууль эрх зүйн орчин

Монгол Улсын хувьд эрүүгийн хэргийг шүүн таслах ажиллагаатай холбоотой харилцааг бүхэлд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулсан байх бөгөөд тус хуулийн Гучин гуравдугаар бүлгээс Дөчдүгээр бүлгийн хооронджурамласан байна. Анхан шатны шүүхийн ажиллагааг Гучин гуравдугаар бүлгээс Гучин тавдугаарт бүлэгт, давж заалдах шатны шүүхийн ажиллагааг Гучин есдүгээр бүлэгт, хяналтын шатны шүүхийн ажиллагааг Дөчдүгээр бүлэгт хуульчилжээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, ...хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.” гэж зааснаас үзвэл зөвхөн мөрдөн шалгах ажиллагаа төдийгүй шүүн таслах ажиллаагаа ч мөн адил шуурхай байх ёстой аж.

Гэвч манай улсын шүүн таслах ажиллагааны нөхцөл байдлын судалгаанаас харвал, хэргийн оролцогч нарын ирцээс хамааран шүүх хуралдаан олон удаа хойшилдог, ялангуяа олон оролцогчтой хэргийн тухайд шүүн таслах ажиллагаа удаашрах нь түгээмэл байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шүүх хуралдааныг хойшлуулж болох дараах үндэслэлийг нэрлэн заажээ.

1. Шүүх хуралдаанд оролцвол зохих тал, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч ирээгүй;
2. Шүүх хуралдаанд нэмэлт шинжилгээ хийлгэх, туршилт хийх, газар, орон байранд үзлэг хийхийг талууд харилцан зөвшөөрсөн;
3. Улсын яллагч, өмгөөлөгч солигдож, эсхүл нэмэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон;
4. Шүүх хуралдааныг хойшлуулах хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон.

Нөхцөл байдлын судалгаанаас харвал, шүүх хуралдааныг хойшлуулсан тохиолдол нь дээрх зүйлийн 1 дэх үндэслэлд зонхилох хувь нь хамаарч байгаа юм. Үндсэндээ, өмгөөлөгчийн ирцтэй холбоотойгоор шүүх хуралдааныг хойшлуулах нь түгээмэл байдаг ажээ.

Хууль тогтоогч шүүн таслах ажиллагааг аль болох богино хугацаанд явуулах боломжийг бүрдүүлэх үүднээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16

дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэл нь хоёр ба түүнээс дээш удаа давтагдаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд санаатай саад учруулах нөхцөл болж байвал шүүх хуралдааныг хойшлуулахгүй байж болно.” гэж шүүхэд эрх олгосон хэм хэмжээ байх боловч зарим тохиолдолд хэрэглэх боломжгүй байдаг байна.

Тухайлбал, хэд хэдэн шүүгдэгчтэй бөгөөд тэдгээрийн хэн нэгэн нь өмгөөлөгч авсан бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.5 дахь заалтад зааснаар бусад шүүгдэгч нар заавал өмгөөлөгчтэйгөөр шүүх хуралдаанд оролцох шаардлагатай болдог.

Түүнчлэн, хууль тогтоогч хэргийг тусгаарлаж хэлэлцэх журмыг 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.18 дугаар зүйлд шинээр оруулсан боловч үндэслэл нь хязгаарлагдмал байна. Тодруулбал, зарим шүүгдэгч хүндэтгэн үзэх шалтгаанаар шүүх хуралдаанд оролцох боломжгүй болсон бол түүнд холбогдох хэргийг тусгаарлаж, шүүх хуралдааныг үргэлжлүүлэн хэргийг эцэслэн шийдвэрлэх боломжтой.

Хэрэв энэхүү зохицуулалтын үндэслэлийг нэмэгдүүлж, шүүх хуралдааныг хойшлуулах шалтгаан болоод байгаа өмгөөлөгч гэх мэт бусад оролцогч ирээгүй тохиолдолд тусгаарлаж хэлэлцэх нөхцөлийг бүрдүүлбэл шүүн таслах ажиллагаа удаашрах эрсдэлийг бууруулах боломжтой гэж судлаачийн хувьд дүгнэж байна. Гэхдээ энэ зохицуулалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хязгаарлалттай уялдах хэрэгтэй юм.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд олон оролцогчтой хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх процессын талаарх гадаадын зарим орны туршлага

Бүгд Найрамдах Хорват Улс

Бүгд Найрамдах Хорват Улс (Хорват) нь хуучин социалист систем задран унаж байх үед буюу 1991 онд тухайн үеийн Холбооны Бүгд Найрамдах Социалист Югослав Улсын бүрэлдэхүүнээс гарч тусгаар тогтносон, парламентын засаглалтай, ардчилсан улс юм.[2]

Хорват Улсын эрх зүйн систем нь Ром Германы буюу эх газрын эрх зүйн бүлд багтдаг бөгөөд бичмэл хууль, дүрэм журамд суурилсан тогтолцоо юм. 1991 оноос хойш Европын Холбоонд элсэх хүртэл эрх зүйн хэд хэдэн томоохон шинэчлэл хийгдэхэд Австри-Унгарын, Герман, Францын хууль эрх зүйн уламжлал болон социалист хуулийн практик тус улсын эрх зүйн тогтолцоо бүрэлдэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Хорват улс ЕХ-нд элсэж, тус холбооны хууль зүйн орчинд нэгдсэнээр хүний эрх, худалдаа, олон улсын хамтын ажиллагаа зэрэг хууль эрх зүйн шинэ чиг хандлагууд бүрдэн тогтсон байна.[3]

Хууль эрх зүйн орчин

[2] https://www.britannica.com/place/Croatia
[3] https://www.nyulawglobal.org/globalex/croatia1.html

Хорват Улсын эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх үйл ажиллагаа, түүн дотор олон оролцогч буюу яллагдагчтай хэргийн хянан шийдвэрлэх журмыг дараах эрх зүйн актуудаар[4] зохицуулагддаг байна. Үүнд:

- Үндсэн хууль (Constitution of Croatia, Ustav Republike Hrvatske, 1991)[5]: Тус улсын Үндсэн хуулиар хүний шударга шүүхээр шүүлгэх, хууль, шүүхийн өмнө эрх, тэгш байх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайг зөвхөн шүүхээр тогтоох зэрэг үндсэн зарчмуудыг баталгаажуулсан.
- Эрүүгийн хууль (Penal Code, Kazneni zakon, 2010)[6]: Тус хуулиар гэмт хэрэг, гэмт хэрэгтэн, түүнд оногдуулах ял, ялыг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл зэргийг тодорхойлдог.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (Criminal Procedure Act, Zakon o kaznenom postupku, 2009)[7]: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, мөрдөн шалгах, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх, яллагдагч, шүүгдэгчийн эрх, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх, үнэлэх шүүх хуралдаан явуулах журам зэргийг тогтоосон эрүүгийн процессын гол хууль.
- Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албаны тухай хууль (2001)[8]: Уг хууль 2001 оны 10 дугаар сарын 19-ний өдөр хүчин төгөлдөр болсон. Энэ хуулийн дагуу Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх алба 2001 оны 12 дугаар сарын 3-ны өдрөөс ажиллаж эхэлсэн.
- Хүний эрхийн тухай Европын конвенц (European Convention on Human Rights (ECHR) 1950): Хүний салшгүй эрхүүд болон шүүгдэгчийн эрхийн талаар тус конвенцод тусгагдсан байдаг.

Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах

Хоёр ба түүнээс олон хүн гэмт хэрэг үйлдэхээр санаатай нэгдсэнийг гэмт хэрэгт хамтран оролцох гэдэг. Хорват улсын Эрүүгийн хуулийн 35 дугаар[9] зүйлд гэмт хэрэгт хамтран оролцох хэлбэрүүдийг тогтоосон. Тэдгээрт гүйцэтгэгч, зохион байгуулагч, хатгагч, хамжигч нар багтах бөгөөд тэдгээрт гэмт хэргийг үйлдэхэд гүйцэтгэсэн үүрэг, оролцоог харгалзан ялыг ялгамжтай оногдуулдаг байна.
Зарчмын хувьд гэмт хэрэг үйлдсэн үйлдэл тус бүрд эрүүгийн хэрэг үүсгэн шалгах ёстой боловч тус улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 29 дугаар зүйлд[10] зааснаар дараах тохиолдолд хэргийг нэгтгэн хянан шийдвэрлэж болдог. Үүнд:

- Нэг яллагдагч хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн;
- Хэд хэдэн яллагдагч нэг эсхүл хэд хэдэн гэмт хэрэг хамтран үйлдсэн;
- Тухайн гэмт хэрэг нэгэнт үйлдэгдсэний дараа гэмт хэргийг нуун дарагдуулахад тусалсан, мэдээлээгүй хамжигч, туслагч;
- Гэмт хэргийн улмаас хохирсон этгээд гэмт этгээдийн эсрэг хариу гэмт хэрэг үйлдсэн.

[4] https://uskok.hr/en/legislation
[5] https://rai-see.org/php_sets/uploads/2015/08/CONSTITUTION_CROATIA.pdf
[6] https://www.vsrh.hr/custompages/static/hrv/files/legislation__criminal-code.pdf
[7] https://www.vsrh.hr/CustomPages/Static/HRV/Files/Legislation__Criminal-Procedure-Act.pdf
[8]https://rai-see.org/php_sets/uploads/2015/08/Legislation__Office-for-the-Suppression-of-Corruption-and-Organized-Crime.pdf
[9] https://www.vsrh.hr/custompages/static/hrv/files/legislation__criminal-code.pdf
[10] https://www.vsrh.hr/CustomPages/Static/HRV/Files/Legislation__Criminal-Procedure-Act.pdf

Түүнчлэн хэд хэдэн яллагдагч хэд хэдэн гэмт хэрэгт үйлдсэн тохиолдолд тэдгээрийн үйлдсэн гэмт хэрэг нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд нотлох баримт нэг байх тохиолдолд тэдгээрийн хэргийг хамтатгаж нэгтгэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж болно.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад хангалттай нотлох баримт цугларсан тохиолдолд хэрэгт холбогдсон бүх яллагдагч нарт хамтарсан яллах дүгнэлт үйлддэг.

Яллах дүгнэлтэд яллагдагч нэг бүрийн гүйцэтгэсэн үүрэг, үйлдэл, гэм буруу түүнчлэн тухай гэмт хэрэгт хамтран оролцсон оролцооны шинж чанар байдлыг ялгаж салган тусгасан байх ёстой.

Яллах дүгнэлт үйлдэгдсэнээр тухайн хэргийг шүүхэд шилжүүлнэ. Шүүгдэгч бүр дараах эрхтэй. Үүнд:

- Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрх;
- Гэм буруутай нь шүүхээр тогтоогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох;
- Дуугүй байх эрх.

Хорват Улсад хөнгөн эрүүгийн хэргийг хотын шүүх (općinski sud), хүндэвтэр, хүнд гэмт хэргийг мужийн шүүх (županijski sud) анхан шатны журмаар тус тус хянан хэлэлцдэг. Олон оролцогчтой, нэгтгэсэн гэмт хэргийн тухайд зарим гэмт хэрэг нь доод, зарим гэмт хэрэг дээд шатны шүүхэд тус тус харьяалагдаж байвал тухайн хэргийг дээд шатны шүүх нь харьяалан шийдвэрлэдэг байна.

Мөн олон оролцогчтой хэргийг заавал шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэдэг бөгөөд гол төлөв 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй байна. Олон шүүгдэгчтэй гэмт хэргийг шүүх шүүгдэгч, гэрчийн тоо, ялын шинж чанар зэрэг хэргийн нарийн төвөгтэй байдлыг харгалзан үзэж шийдвэрлэдэг.

Эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг хойшлуулах

Хорват Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 326 дугаар зүйлд шүүх хуралдааныг хойшлуулах гол үндэслэл, нөхцөлийг заасан байдаг. Энэхүү зүйлд:

1. Шинээр нотлох баримт олж авах зайлшгүй шаардлага байгаа бол;
2. Шүүх хуралдааны явцад тухайн шүүгдэгчийн зүйлчлэлийн асуудлыг эргэн харахаар бол;
3. Шүүх хуралдааныг цааш үргэлжлүүлэхэд хүндрэлтэй хүндэтгэн үзэх бусад шалтгаан байна гэж үзсэн бол шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохыг тус тус дурдсан.

Шүүх хуралдааныг хойшлуулахдаа тус шүүх хуралдааныг үргэлжлүүлэх өдөр, цагийг тухайн шүүх хуралдааныг хойшлуулах шийдвэрт боломжтой бол тодорхой тусгана. Мөн шүүх цаг хугацааны явцад үрэгдэж, алга болж болзошгүй нотлох баримтыг нэн даруй олж авахыг тухайн шийдвэрээр холбогдох эрх бүхий албан тушаалтанд даалгаж болно.

Шүүгдэгч, түүний өмгөөлөгч ирээгүй, эсхүл үндэслэл бүхий шалтгаангүй ирүүлээгүй бол шүүх нөхцөл байдлыг харгалзан шүүх хуралдааныг үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэж болох тухай болон холбогдох бусад нөхцөлийг 322 дугаар зүйлд тусгажээ. Шүүх яллагдагч, түүний өмгөөлөгчийг шүүх хуралдаанд зайлшгүй оролцуулах шаардлагагүй гэж үзвэл шүүх хуралдааныг үргэлжлүүлж болно.

Улсын яллагч ирээгүй тохиолдолд шүүх хурлыг хойшлуулна гэж 321 дүгээр зүйлд, гэрч, шинжээч учир шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй бол шүүх хуралдаанд гаргах мэдүүлэг, тайлбарын ач холбогдлыг харгалзан шүүх тус хуралдааныг хойшлуулах, эсхүл завсарлуулах эсэхийг шийдвэрлэнэ гэж 325 дугаар зүйлд тус тус заасан байна. Шүүх хуралдааныг хойшлуулах тухай шийдвэрийг эс зөвшөөрсөн гомдол гаргах боломжгүй буюу талууд тухайн шийдвэрийг давж заалдах эрхгүй байдаг байна.

Хорват Улсын хувьд өндөр түвшний авлигын болон зохион байгуулалттай гэмт хэргүүд олон оролцогчтой нарийн төвөгтэй байх нь олонтоо. Иймээс эдгээр хэрэгт мөрдөн шалган ажиллагаа явуулдаг Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх алба (Office for the Suppression of Corruption and Organized Crime, Ured za suzbijanje korupcije i organiziranog kriminaliteta, USKOK)[11]-ны үүрэг оролцоо их байдаг.

Кейс судалгаа: “ФИМИ Медиа” (FIMI Media)-гийн хэрэг[12]

Хорват Улс дахь авлигын, зохион байгуулалттай олон оролцогч бүхий, томоохон гэмт хэргийн тод жишээ бол Хорватын Ерөнхий сайд асан Иво Санадерын холбогдсон “ФИМИ Медиа”-гийн дуулиант хэрэг юм. Тус хэрэг Иво Санадер Хорват Улсын Ерөнхий сайд хийж асан 2003-2009 оны хооронд үйлдэгдсэн ажээ. Энэхүү хэрэг нь төрийн худалдан авах үйл ажиллагаа болон төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой компани, хувийн хэвшлийн байгууллагуудыг “ФИМИ Медиа” хэмээх хувийн маркетингийн агентлагтай гэрээ байгуулж, мөнгө шилжүүлэхийг албан тушаалын байдлаа ашиглан тулгах, дарамтлах, хясан боогдуулах, элдэв давуу байдал олгох амлалт өгөх зэргээр төсвийн хөрөнгийг шамшигдуулж, улмаар эрх баригч улс төрийн хүчин - Хорватын ардчилсан холбоо (ХАХ)-г далдуур санхүүжүүлсэн, мөн хувьдаа завшсан төрийн өндөр албан тушаалтнуудын зохион байгуулалттай хэрэг юм.

Энэ хэрэгт Ерөнхий сайд асан Иво Санадер, Гаалийн албаны дарга Младен Баришич, тухайн үеийн эрх баригч улс төрийн хүчин - ХАХ-ны өндөр албан тушаалтнууд, “ФИМИ Медиа” компанийн эзэн Невенка Журак зэрэг улс төрд нөлөө бүхий хэд хэдэн этгээдийг ялласан. Тэдний авлигын схемээс үр шимийг нь хүртэж байсан хүмүүсийн тухайд, дээр дурдсан яллагдагчаар татагдсан этгээдүүдээс гадна, тэднээс ямар нэг хэлбэрээр хахууль авсан, өгсөн хаалгач, бие хамгаалагчаас эхлээд нарийн бичгийн дарга, сайд хүртэл бүх түвшний ажилтнууд багтсан ХАХ-ны 30 гаруй гишүүн байжээ. Жишээлбэл: Марижан Приморак 322,368 евро хандивлаж, Иво Санадерт BMW бэлэглэсний хариуд түүний "Приморка" компани нь “Хорватын сугалаа” (Croatian Lottery) төрийн өмчит компанийн оффист ашигтай байрлалтай талбай түрээслэх давуу гэрээ байгуулсан. Мөн Миха Зрнич Маринович 263,157 евро хандивлаж, Байгаль орчныг хамгаалах сан (төрийн)-тай хамтран улсын төсвийг хэдэн саяар нь урсгадаг “Одлагалиште сировина” (Түүхий эдийн хогийн цэг)-ийг эзэмшдэг болсон байна.

Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Авлига, Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх алба “Фими Медиа” компанийн эзэн Невенка Журакийг 2010 онд баривчилсан нь дээрх улс төрийн элитүүдийн оролцоог илчлэхэд хүргэсэн. Хэргийн гол зохион байгуулагч Иво Санадер 2011 оны сүүлээр Хорватаас зугтаж, оргон зайлсан боловч Австри улсаас баривчлагдаж Хорват руу буцаан шилжүүлэгдсэн байна. 2012 онд Иво Санадерыг "Фими Медиа"-гийн авлигын хэрэгт бусад оролцогчийн хамт буруутган, түүнд 10 жилийн хорих ял оноосон боловч хожим нь Хорватын Үндсэн хуулийн шүүх 2015 онд түүний ялыг хүчингүй болгож байжээ. 2020 оны 11 дүгээр сард түүнийг тус хэргээр

[11] https://uskok.hr/en/legislation
[12] https://anticorrp.eu/wp-content/uploads/2015/08/FIMI-Media-Case-Study-EN.pdf

дахин буруутгаж 8 жилийн ял өгсөн байна. Ийнхүү тухайн хэргийг хянан шийдвэрлэхэд 10 орчим жил зарцуулжээ.

Түүнчлэн Невенка Журак болон бусад албан тушаалтнууд мөн хорих ял авч, ХАХ-г олон сая еврогоор торгожээ. Хорватад улс төрийн нам авлигын хэргээр ял сонсож, хариуцлага хүлээсэн анхдагч тохиолдол болж, ХАХ нам өөрөө хууль бус хөрөнгөөс буюу эх үүсвэрээс санхүүжсэнийхээ төлөө хариуцлага хүлээсэн юм.

“ФИМИ медиа”-ийн хэрэг нь Хорватын хууль сахиулах байгууллагууд, ялангуяа Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх алба, авлигын эсрэг шүүх тус улсын хамгийн эрх мэдэлтэй хүмүүс, түүн дотор Ерөнхий сайд асан хүнийг ч яллах шийдвэр гаргаж чадаж байгааг харуулсан бөгөөд Хорватын авлигын эсрэг тэмцэлд чухал үйл явдал болсон байна. Энэхүү хэргийг хянан шийдвэрлэх үйл явц, хэргийн шийдвэрлэлт нь иргэдийн төрд итгэх итгэлд ихээхэн эерэг нөлөө үзүүлж, улс төрд ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэхэд том сургамж болсон.

БҮГД НАЙРАМДАХ ЭСТОНИ УЛС

Бүгд Найрамдах Эстони Улс (Эстони) 1940 онд Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан бөгөөд 1991 оноос тусгаар тогтносон, парламентын засаглалтай, ардчилсан улс юм. Мөн Эстонийн эрх зүйн систем Ром-Германы эрх зүйн бүлд багтдаг.

Хууль эрх зүйн зохицуулалт

Эстонид олон оролцогчтой эрүүгийн гэмт хэргийг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулсан байна.

Эрүүгийн хууль

Эстонийн Эрүүгийн хуульд эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэмт хэрэгтнүүдийн ангиллыг тодорхойлсон. Хуулийн 20 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэгтнийг *гол гэмт хэрэгтэн ба хамсаатан* гэж ангилсан байна[13]. Түүнчлэн хуульд дараах ойлголтуудыг тодорхойлжээ. Үүнд:[14]

- Гол гэмт хэрэгтэн гэж гэмт хэрэг үйлдэхдээ бусдын оролцоогүй дангаараа, эсхүл бусдыг ашиглах замаар хэрэг үйлдсэн хүнийг хэлнэ. Хэрэв 2 ба түүнээс дээш хүн хамтран гэмт хэрэг үйлдэхээр тохиролцсон бол тухайн хүн бүр гол гэмт хэрэгтэн (хамтарсан гол гэмт хэрэгтнүүд) байхаар тодорхойлсон. Хэд хэдэн этгээд тохиролцсоны үндсэн дээр хамтран үйлдсэн хэрэг нь гэмт хэргийн зайлшгүй бүрэлдэхүүнийг бүрдүүлсэн бол гэмт хэргийг хамтран үйлдсэн гэмт хэрэг гэж үзнэ.
- Хамсаатан гэж гэмт хэргийн өдөөн хатгагч болон гэмт хэрэг үйлдэхэд тусалсан хүн (хамжигч)-ийг хэлнэ. Бусдыг санаатайгаар хууль бус үйлдэл хийхэд өдөөсөн этгээдийг *өдөөн хатгагч*, харин бусдын санаатай, хууль бус үйлдэлд биечлэн оролцох, эд материалын болон сэтгэл санааны тусламжийг санаатайгаар үзүүлсэн этгээдийг *тусалсан хүн (хамжигч)* гэж тус тус тодорхойлсон байна.

Хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэргийн хамсаатанд гол гэмт хэрэгтнийхтэй ижил хуулийн заалтын дагуу ял шийтгэл ногдуулж болохоор тусгасан

[13] Penal Code[1], § 20.Offender, https://www.riigiteataja.ee/en/eli/522012015002/consolide
[14] Penal Code[1]**§ 21.**Principal offender, **§ 22.**Accomplice, https://www.riigiteataja.ee/en/eli/522012015002/consolide

байна. Гэхдээ тусалсан хүний (хамжигчийн) хувьд шүүхээс ял шийтгэл ногдуулахдаа энэ хуульд заасны дагуу ялыг хөнгөвчилж болохоор зохицуулжээ[15].

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Эрүүгийн хэргийг нэгтгэх, тусгаарлах[16]

Эстонийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхдээ хэргийг нэгтгэх, тусгаарлах талаар тусгасан байна.

Хэрэв тухайн хүмүүсийг хамтдаа эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэж, эсхүл яллаж байгаа бол хэд хэдэн эрүүгийн хэргийг хамтад нь хянан шийдвэрлэхээр нэгтгэж болохоор заасан. Үүнд:

- Хэд хэдэн эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн;
- Эрүүгийн гэмт хэргийг нуун далдлах, эсхүл гэмт хэргийн талаар мэдээлээгүй байх зэрэг орно.

Түүнчлэн тухайн сэжигтэн, эсхүл яллагдагчтай эрүүгийн хэргийг хамтдаа үйлдсэн гэж сэжиглэгдэж, эсхүл яллагдаж байгаа этгээдийн хэргийг тусгаарлаж болохоор зохицуулжээ. Үүнд:

- Тухайн хүн хаана байгаа нь тодорхойгүй, эсхүл эрүүгийн хэрэг хянах шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос оргон зайлсан, эсхүл гадаадад хорих ял эдэлж байгаа, эсхүл зохих хугацаанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй бусад шалтгаантай байх;
- Тухайн хүн гадаад улсын иргэн байх, эсхүл гадаадад байгаа;
- Тухайн хүн шүүх хуралдааны өмнөх процесс дууссаны дараа энэ хуульд заасны дагуу эрүүгийн хэргийг өөр хэрэг хянан шийдвэрлэх, эсхүл эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хэрэглэх хүсэлт гаргасан боловч хэрэглэхийг зөвшөөрөөгүй[17] зэрэг орно.

Түүнчлэн эрүүгийн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусахаас сэргийлэх, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны боломжит хугацааг хангах шаардлагатай бол эрүүгийн хэргийг нэг буюу хэд хэдэн эрүүгийн гэмт хэргийн бүрэлдэхүүнээс тусгаарлаж болохоор заасан байна.

Хэрэв насанд хүрээгүй хүн насанд хүрсэн хүнтэй хамт эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн гэж сэжиглэгдэж, эсхүл яллагдаж байгаа тохиолдолд насанд хүрээгүй хүний хэргийг тусад нь авч үзэх журам байдаг эсэхээс үл хамааран тусад нь эрүүгийн хэрэг үүсгэж болно.

Эрүүгийн хэргийг нэгтгэх болон тусгаарлахдаа мөрдөн байцаах, эсхүл прокурорын байгууллагын, эсхүл шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлнэ. Энэхүү шийдвэрийн хуулбарыг шинэ хавтаст хэрэгт хавсаргана.

Шүүхийн хуралдааныг хойшлуулах

Эстонийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг дараах тохиолдолд хойшлуулж болохоор заасан байна. Үүнд[18]:

[15] Penal Code[1], **§ 60.**Mitigation of punishment in cases provided by law, https://www.riigiteataja.ee/en/eli/522012015002/consolide
[16] Code of Criminal Procedure, § 216. Joinder and severance of criminal matters, https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide
[17] Code of Criminal Procedure, **§ 233.**Grounds for application of alternative proceedings, (2), **§ 239.**Grounds for application of settlement proceedings, (2), https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide
[18] Code of Criminal Procedure, **§ 273.** Adjournment of court hearing, https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide

- Хуульд заасны дагуу гэрч, хохирогч, эсхүл шинжээч, прокурор, өмгөөлөгч, яллагдагч шүүх хуралдаанд зайлшгүй оролцохоор тохиолдолд ирээгүй;
- Нэмэлт нотлох баримт шаардлагатай;
- Хэлэлцүүлгийн явцад өөр эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэх сэжүүр үүссэний улмаас эрүүгийн хэргийг хэлэлцэхэд хүндрэлтэй болсон;
- Шүүх хуралдааныг өөр бусад шалтгааны улмаас үргэлжлүүлэх боломжгүй болсон зэрэг орно.

Шүүхийн хуралдааныг хойшлуулахаас өмнө гэрч, хохирогч, мэргэшсэн этгээд, шинжээч, иргэний хариуцагч нь шүүх хуралдаанд оролцсон бол бусад шүүх хуралдаанд дуудах шаардлагагүй.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох шаардлагатай этгээд ирээгүйн улмаас шүүхийн хуралдааныг хойшлуулсан бөгөөд ийнхүү ирэхгүй байх нь хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаантай[19] биш бол шүүхээс хуульд заасны дагуу торгуулийн арга хэмжээ авна. Түүнчлэн албадан ирүүлэх, эсхүл оргон зайлсан гэж зарлах зэрэг арга хэмжээг авч болохоор тусгасан байна.

Хэрэв өмгөөлөгч эрүүгийн хэргийн талаар мэдээлэлгүй байгаа бол шүүх хуралдааныг 10 хүртэл хоногоор хойшлуулж, шүүх хуралдааныг хойшлуулсантай холбогдох эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлыг өмгөөлөгчөөс гаргуулж болно. Энэ тухай Өмгөөлөгчдийн холбооны удирдлагад мэдэгдэнэ.

Шүүхийн хуралдааныг хойшлуулсан тохиолдолд түүнийг үргэлжлүүлэн явуулах хугацааг нэн даруй товлоно. Хуралдааныг аль болох богино хугацаанд хойшлуулах болон үргэлжлүүлэхдээ эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг тасралтгүй явуулах зарчмыг баримтлахаар заасан байна.

[19] Code of Criminal Procedure, **§ 170.** Good reason for failure to appear when summoned, https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

МОНГОЛ УЛС

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль https://legalinfo.mn/mn/detail/12694
2. Шүүх хурал хойшлох шалтгаан, нөхцөлийг тодруулах нь https://judcouncil.mn/file/research/3
3. Шүүх хуралдаан хойшлуулсан, шүүхээс хэрэг түдгэлзүүлсэн үндэслэл, шалтгаанд хийсэн тойм судалгаа https://judcouncil.mn/file/research/13
4. Шүүхийн академи https://jtrii.mn/mn/news/81
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай https://supremecourt.mn/
6. Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа https://supremecourt.mn/
7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас хохирлыг нөхөн төлүүлэх хэрэг:шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ https://forum.mn/uploads/site/1126/res_mat/2021/RS_21_CPC%20Chapter45.pdf
8. Шүүхийн шийдвэрийн судалгаа https://forum.mn/product/211384

ХОРВАТ УЛС

9. https://www.britannica.com/place/Croatia
10. https://www.nyulawglobal.org/globalex/croatia1.html
11. Хорват Улсын Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх алба:https://uskok.hr/en/legislation
12. Хорват Улсын Үндсэн Хууль: https://rai-see.org/php_sets/uploads/2015/08/CONSTITUTION_CROATIA.pdf
13. Хорват Улсын Эрүүгийн хууль: https://www.vsrh.hr/custompages/static/hrv/files/legislation__criminal-code.pdf
14. Хорват Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль: https://rai-see.org/php_sets/uploads/2015/08/Croatia_Criminal_proc_code_am2009_en.pdf
15. Хорват Улсын Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх албаны тухай хууль: https://rai-see.org/php_sets/uploads/2015/08/Legislation__Office-for-the-Suppression-of-Corruption-and-Organized-Crime.pdf
16. ФИМИ Медиагийн хэрэг: https://anticorrp.eu/wp-content/uploads/2015/08/FIMI-Media-Case-Study-EN.pdf

ЭСТОНИ УЛС

17. Penal Code[1], § 20.Offender, https://www.riigiteataja.ee/en/eli/522012015002/consolide
18. Penal Code[1]**§ 21.**Principal offender, **§ 22.**Accomplice, https://www.riigiteataja.ee/en/eli/522012015002/consolide
19. Penal Code[1], **§ 60.**Mitigation of punishment in cases provided by law,
20. Code of Criminal Procedure, § 216. Joinder and severance of criminal matters, https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide
21. Code of Criminal Procedure, **§ 233.**Grounds for application of alternative proceedings, (2), **§ 239.**Grounds for application of settlement proceedings, (2), https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide
22. Code of Criminal Procedure, **§ 273.** Adjournment of court hearing, https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide
23. Code of Criminal Procedure, **§ 170.** Good reason for failure to appear when summoned, https://www.riigiteataja.ee/en/eli/530102013093/consolide